

БАТЛАВ  
СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН БИЧГИЙН  
ДАРГА ЧЦЭВЭГДОРЖ

**“МУЗЕЙН НЭЭЛТТЭЙ ӨДРҮҮД” АРГА ХЭМЖЭЭГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

**Нэг.Зорилго**

Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод заасан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйл, урлагийн бүтээлээр дамжуулан хүүхэд залуучуудад үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн музейгээс зохион байгуулна.

**Хоёр.Хугацаа**

2.1.2024 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдрийг дуустал хэрэгжүүлнэ.

**Гурав. Үйл ажиллагааны чиглэл**

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн музейгээс үйлчилгээний чанар хүртээмжээ нэмэгдүүлэн, олон нийтийн оролцоог хангасан тусгай үзэсгэлэн, боловсролын хөтөлбөр, лекц, уулзалт зэрэг нийгэмд чиглэсэн б,

усад арга хэмжээг танхим болон цахимаар дараах чиглэлийн дагуу зохион байгуулах. Үүнд:

3.1.1.“Музейн нээлттэй өдрүүд”-ээр төрийн болон орон нутгийн өмчийн музей иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх,

3.1.2.Монгол Улсад орчин цагийн музей байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг нээж музейн түүхээ сурталчлах,

3.1.3.“Эрх орончдын өдөр” 3 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх үйлсэд онцгой гавьяа байгуулсан Улсын баатар, Ходолморийн баатар гавьяат үйлэтнийг алдаршуулах,

3.1.4.Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан орон нутгийн музейнүүд төр хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг орон нутгийн төрийн захиргааны байгууллагатайгаа хамтран зохион байгуулах,

**Дөрөв. Зохион байгуулалт**

4.1. “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас нэгдсэн өнгө төрхийг илэрхийлэх брэндбүүк, логог төрийн болон орон нутгийн музейд хүргүүлж мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

4.1. Аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн музейн, төрийн өмчийн музей өөрийн музейн “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээний төлөвлөгөөгөө гарган 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн дотор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт ирүүлсэн байна.

4.2. “Музейн нээлттэй өдрүүд”-ээр аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн музейн арга хэмжээнд оролцогчдын тоон мэдээгээ, төрийн өмчийн музей өөрийн музейн арга хэмжээнд оролцогчдын тоон мэдээгээ өдөр бүр 16.00 цагаас өмнө Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт цахим шуудангаар /info@culture.gov.mn/ тус тус ирүүлнэ.

4.3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар төрийн болон орон нутгийн өмчийн музейн арга хэмжээнд оролцогчдын тоон мэдээгээ нэгтгэн 17.00 цагаас өмнө Соёлын яаманд цахим шуудангаар ирүүлнэ.

4.5. Төрийн болон орон нутгийн музейнүүд “Музейн нээлттэй өдрүүд”-ээр үзмэр, эд өлгийн зүйлийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалдаа онцгой анхаарал хандуулж хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд тодорхой зохицуулалтыг хийж ажиллана.

4.6. Музейн үйлчилгээний ажилтан, албан хаагчдын хөдөлмөрийн хуваарь, удирдлага зохион байгуулалтыг нарийвчлан төлөвлөж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.

#### Тав. Тайлагнах

5.1. Аймаг, нийслэлийн соёл, урлагийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн музейн “Музейн нээлттэй өдрүүд”-ийн үйл ажиллагааны тайланг, Төрийн өмчийн музей өөрийн үйл ажиллагааны тайлангаа 2024 оны 3 дугаар сарын 08-ны өдрийн дотор гаргаж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт цахим шуудангаар /info@culture.gov.mn/ тус тус илгээнэ.

5.2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар нь төрийн болон орон нутгийн өмчийн музейн “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээний тайлангаа нэгтгэн 2024 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор Соёлын яаманд ирүүлнэ.